| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 165,567,000.00 | 165,450,150.00 | 116,850.00 | 98.99 |
| 210104 | Урамшуулал | 165,567,000.00 | 165,450,150.00 | 116,850.00 | 98.99 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 20,695,800.00 | 20,695,800.00 | - | 93.80 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 14,073,200.00 | 14,073,200.00 | - | 95.89 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 1,655,700.00 | 1,655,700.00 | - | 89.35 |
| 210203 | ҮОМШӨ ний даатгал | 827,800.00 | 827,800.00 | - | 73.47 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 827,800.00 | 827,800.00 | - | 73.47 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 3,311,300.00 | 3,311,300.00 | - | 97.29 |
| 2201 | Бараа үйлчилгээний бусад зардал | 26,636,000.00 | 26,636,000.00 | - | 99.84 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 26,636,000.00 | 26,636,000.00 | - | 99.84 |
| | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 49,466,800.00 | 49,466,800.00 | - | 100.00 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 49,466,800.00 | 49,466,800.00 | - | 100.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж урамшуулал | 49,466,800.00 | 49,466,800.00 | - | 100.00 |
| | ХӨТӨЛБӨР 71802 | - | - | - | - |
| | АРГА ХЭМЖЭЭ 81844 | - | - | - | - |
| 2 | I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 2,800,000.00 | 2,800,000.00 | - | 73.76 |
| 21 | УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН | 2,800,000.00 | 2,800,000.00 | - | 73.76 |
| 210 | Бараа, үйлчилгээний зардал | 2,800,000.00 | 2,800,000.00 | - | 73.76 |
| 2201 | Бараа үйлчилгээний бусад зардал | 2,800,000.00 | 2,800,000.00 | - | 73.76 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 2,800,000.00 | 2,800,000.00 | - | 73.76 |
| | ХӨТӨЛБӨР 71802 | - | - | - | - |
| | АРГА ХЭМЖЭЭ 81848 | - | - | - | - |
| 2 | I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 4,806,700.00 | 4,806,700.00 | - | 44.21 |
| 21 | УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН | 4,806,700.00 | 4,806,700.00 | - | 44.21 |
| 210 | Бараа, үйлчилгээний зардал | 4,806,700.00 | 4,806,700.00 | - | 44.21 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр | 4,806,700.00 | 4,806,700.00 | - | 44.21 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 4,806,700.00 | 4,806,700.00 | - | 44.21 |
| | ХӨТӨЛБӨР 71802 | - | - | - | - |
| | АРГА ХЭМЖЭЭ 81875 | - | - | - | - |
| 2 | I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 15,048,000.00 | 7,471,630.43 | 7,576,369.57 | 69.37 |
| 21 | УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН | 15,048,000.00 | 7,471,630.43 | 7,576,369.57 | 69.37 |
| 210 | Бараа, үйлчилгээний зардал | 15,048,000.00 | 7,471,630.43 | 7,576,369.57 | 69.37 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр | 15,048,000.00 | 7,471,630.43 | 7,576,369.57 | - |
| 210806 | Мэдээллийн технологийн зардал | 15,048,000.00 | 7,471,630.43 | 7,576,369.57 | - |
| 2201 | Бараа үйлчилгээний бусад зардал | - | - | - | - |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | - | - | - | - |
| | ХӨТӨЛБӨР 71802 | - | - | - | - |
| | АРГА ХЭМЖЭЭ 83602 | - | - | - | - |
| 2 | I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 1,200,000.00 | 1,200,000.00 | - | - |
| 21 | УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН | 1,200,000.00 | 1,200,000.00 | - | - |
| 210 | Бараа, үйлчилгээний зардал | 1,200,000.00 | 1,200,000.00 | - | - |
| 2201 | Бараа үйлчилгээний бусад зардал | 1,200,000.00 | 1,200,000.00 | - | - |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 1,200,000.00 | 1,200,000.00 | - | - |
| | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 3,936,972,600.00 | 3,936,972,600.00 | - | - |
| 1310 | УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 3,928,165,900.00 | 3,928,165,900.00 | - | - |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | 3,928,165,900.00 | 3,928,165,900.00 | - | - |
| 120004 | ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС | 8,806,700.00 | 8,806,700.00 | - | - |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 4,806,700.00 | 4,806,700.00 | - | - |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 4,000,000.00 | 4,000,000.00 | - | - |
| 4 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | - | 276,956,255.60 | 276,956,255.60 | - |
| 5 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | - | 333,805,055.54 | 333,805,055.54 | - |
| 6 | ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ | - | - | - | - |
| 61 | БАЙГУУЛЛАГЫН ТОО | - | - | - | - |
| 62 | АЖИЛЛАГСДЫН ТОО | 109.00 | 109.00 | - | 100.00 |
| 620001 | Удирдах ажилтан | 1.00 | 1.00 | - | 100.00 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 87.00 | 87.00 | - | 100.00 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 21.00 | 21.00 | - | 100.00 |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

*2024 оны 12 дугаар сарын 31* *(/төгрөгөөр/)*

## НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТИЙН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Байгууллагын нэр: Тосонцэнгэл сумын ерөнхий боловсролын 2 дугаар сургууль

Тайлант хугацаа: 2024.12.31
/ төгрөгөөр /

| Д/Д | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү дүн | Харьцуулалт |
|---|---|---|---|---|---|
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | - | - | - | - |
| | ХӨТӨЛБӨР 71802 | | - | - | - |
| | АРГА ХЭМЖЭЭ 80109 | - | - | - | - |
| 2 | I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 452,497,600.00 | 431,653,593.72 | 20,844,006.28 | 95.4 |
| 21 | УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН | 452,497,600.00 | 431,653,593.72 | 20,844,006.28 | 95.4 |
| 210 | Бараа, үйлчилгээний зардал | 452,497,600.00 | 431,653,593.72 | 20,844,006.28 | 95.4 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 447,997,600.00 | 427,153,593.72 | 20,844,006.28 | 95.4 |
| 210301 | Гэрэл цахилгаан | 35,958,400.00 | 21,770,758.72 | 14,187,641.28 | 101.44 |
| 210302 | Түлш, халаалт | 384,629,800.00 | 375,049,433.00 | 9,580,367.00 | 100.32 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 27,409,400.00 | 30,333,402.00 | (2,924,002.00) | - |
| 2106 | Эд хогшил худалдан авах | 4,500,000.00 | 4,500,000.00 | - | 100 |
| 210604 | Урсгал засвар | 4,500,000.00 | 4,500,000.00 | - | 100 |
| | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | - | - | - | - |
| 1320 | ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | - | - | - | - |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | - | - | - | - |
| 4 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | - | - | - | - |
| 5 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | - | 0.00 | (0.00) | - |
| 6 | ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ | - | - | - | - |
| 61 | БАЙГУУЛЛАГЫН ТОО | - | - | - | - |
| 62 | АЖИЛЛАГСДЫН ТОО | 109.00 | 109.00 | - | 100.00 |
| 620001 | Удирдах ажилтан | 1.00 | 1.00 | - | 100.00 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 87.00 | 87.00 | - | 100.00 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 21.00 | 21.00 | - | 100.00 |

## 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

**Тосонцэнгэл сумын ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн үйл ажиллагааны *чиглэл:***

- *Боловсролын үйлчилгээ үзүүлэх*

**Тосонцэнгэл сумын ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн зорилго:** Багш ажилтны хамтын ажиллагаанд тулгуурлан сургуулийн таатай орчин бүрдүүлж суралцагчийн эзэмжших чадамжийг дээшлүүлэн хичээл сургалтын чанар үр дүнг сайжруулах, Суралцагч бүрийн оролцоог хангаж, хичээлийн тав тухтай орчинг бүрдүүлж чанарт ахиц гаргах.

### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тосонцэнгэл сумын ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн үйл ажиллагаанд мөрддөг хууль:

1. Боловсролын тухай хууль
2. Бага боловсролын тухай хууль
3. Төрийн албаны тухай хууль
4. Төсвийн тухай хууль
5. Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
6. Нийгмийн даатгалын ерөнхий хууль
7. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
8. Хувь хүний орлогын албан татварын тухай хууль
9. Хөдөлмөрийн тухай хууль
10. Төрийн хэмнэлтийн тухай хууль
11. Шилэн дансны тухай хууль

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

**Байгууллагын дотоод хяналтын талаар:** Засгийн газрын 2011 оны 311 дугаар тушаалаар батлагдсан Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журмын 1.3 "Аж ахуйн нэгж, байгууллага нь энэхүү нийтлэг журамд нийцүүлэн, өөрийн үйл ажиллагааны онцлогт тохирсон "Дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журам"-тай байна" гэж заасан байна. 1.4. Төрийн болон орон нутгийн өмчийн аж ахуйн нэгж, байгууллагын "Дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журам"-ыг Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 7.2, 8.2.1-д заасны дагуу дараахь эрх бүхий этгээд батална: 1.4.1. хуульд өөрөөр заагаагүй бол яам, эрхлэх ажлын хүрээнд нь үйл ажиллагаа явуулж байгаа агентлаг, харьяа бусад байгууллага, аж ахуйн нэгжид мөрдөх "Дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журам"-ыг Монгол Улсын сайд; 1.4.2. өөрийн болон доод шатны Засаг даргын ажлын алба, харьяа байгууллага, аж ахуйн нэгжид мөрдөх "Дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журам"-ыг аймаг, нийслэлийн Засаг дарга. 1.5. Энэхүү журмын 1.4-т заснаас бусад тохиолдолд "Дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журам"-ыг тухайн байгууллага, аж ахуйн нэгж өөрөө баталж мөрдөнө. 1.6. Аж ахуйн нэгж, байгууллага нь дотоод хяналт шалгалтыг зохион байгуулахдаа энэхүү нийтлэг журам болон Монгол Улсын хууль тогтоомж, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газар, эрх бүхий бусад байгууллага, албан тушаалтнаас нийтээр дагаж мөрдүүлэхээр гаргасан шийдвэрийг удирдлага болгоно. 1.7. Хуульд өөрөөр заагаагүй бол аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод аудит, хяналт-шинжилгээ, үнэлгээ (мониторинг) хийхэд энэхүү нийтлэг журам хамаарахгүй.2022 онд

хүний бүрэлдэхүүнтэйажлын хэсэг байгууллагдан ажилласан боловч 2023 он гараад ажлын хэсгийн бүрэлдэхүүн өөрчлөлт орж албан хаагч солигдсон учир дахин ажлын хэсгийг захирал томилоогүй байна.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Тосонцэнгэл сумын ерөнхий боловсролын 2 дугаар сургууль нь 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл суурьар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.4, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан иж бүрдлийн дагуу бэлтгэж толилуулсан байна.

Төсвийн гүйцэтгэлийн тайланг мөнгөн суурьар бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54.5 дахь заалтын дагуу иж бүрэн гаргаж ирүүлсэн.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Тосонцэнгэл сумын ерөнхий боловсролын 2 дугаар сургууль нь 2024 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгө өмнөх оноос 187,211.5 мянган төгрөгөөр буюу 18.4 хувиар өссөн байна.

***Хүснэгт 1.*** *Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөгөөр/*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Авлага | | | |
| Бараа материал | 224,954.6 | 264,138.6 | 39,184.0 |
| Үндсэн хөрөнгө | 4,565,843.8 | 4,657,022.6 | 91,178.8 |
| **Нийт хөрөнгө** | **5,067,754.7** | **5,254,966.3** | **187,211.6** |
| Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ | **5,067,754.7** | **5,135,427.1** | **67,672.4** |
| **Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн** | **5,067,754.7** | **5,254,966.3** | **187,211.6** |

Санхүүгийн тайлангийн тодруулгыг мөнгөн хөрөнгө, үндсэн хөрөнгө, авлага, бараа материал, өр төлбөр гэсэн данс бүрээр холбогдох журам, зааврын дагуу бэлтгэсэн байна.

**Тайланд онд:**

Авлага байхгүй.

Бараа материалын эхний үлдэгдэл 224,954.6 мянган төгрөг, төсвийн хөрөнгөөр 33,201.4 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, хандив тусламжаар газраас 30,354.3 мянган төгрөгийн бараа материал үнэ төлбөргүйгээр нэмэгдэж 264,138.6 мянган төгрөгийн бараа материал зарцуулж, эцсийн үлдэгдэл 264,138.6 мянган төгрөг болж, өмнөх оноос 18,270.6 мянган төгрөгөөр өссөн байна.

Үндсэн хөрөнгийн хувьд худалдаж авсан хөрөнгө 205,519.7 мянган төгрөгийн хөрөнгө, 117,275.8 мянган төгрөгийн хөрөнгө үнэ төлбөргүйгээр нэмэгдэж, 163,328.3 мянган төгрөгийн хөрөнгийг шийдвэрийн дагуу акталж, жилийн эцэст 4,657,022.6 мянган төгрөгийн хөрөнгийн үлдэгдэлтэй байна. Тайлант оны элэгдлийн зардалд 231,616.7 мянган төгрөгийг тооцож бүртгэсэн байна.

Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ 616,475.8 мянган төгрөг нь тайлант онд өөрчлөлт ороогүй болно.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2024 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 4,506,870.7 мянган төгрөг, нийт зарлагыг 4,407,851.4 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна. Цалин, ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэл тодотголоор нэмж баталсан байна.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 14 арга хэмжээг улсын төсвөөс 3,928,165.9 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 452,497.6 мянган төгрөг санхүүжүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 3,814,987.3 мянган төгрөг буюу 97.1 хувьтай байна. Энэ нь цалин хөлс болон нэмэгдэл урамшил 207,223.6 мянган төгрөг, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл 24,276.8, хоол хүнс 13,546.4 мянган төгрөг, мэдээлэл технологийн зардал 7,576.3 мянган төгрөгөөр тус тус хэмнэгдсэнтэй холбоотой байна.

Орон нутгийн төсвийн зардлын гүйцэтгэл 431,653.5 мянган төгрөг буюу 95.3 хувьтай байна. Энэ нь байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 20,844.1 мянган төгрөгөөр, үүнд гэрэл цахилгаан 14,187.6, түлш халаалт 9,580.3 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэнтэй холбоотой байна.

***Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл***

*/мянган төгрөгөөр/*

| Хөтөлбөр арга хэмжээ | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Биелэлт |
|---|---|---|---|---|---|
| **Улсын төсвөөс санхүүжих** | | | | | |
| **71801** | **Сургуулийн өмнөх боловсрол** | | | | |
| 80233 | Хүүхэд хамгаалал | 7,660.6 | 1,826.4 | 5,833.7 | 23.8% |
| 81605 | Эрүүл мэндийг дэмжих | 7,610.3 | 7,610.3 | 0.00 | 100% |
| 80226 | Байр ашиглалттай холбоотой зардал | 7,610.3 | 7,618.0 | -7.7 | 100.1% |
| 80312 | Сургалт семинарын зардал | 5,180.1 | 3,932.0 | 1,248.1 | 75,9% |
| 81801 | Үдийн хоол | 143,829.8 | 157,938.0 | -14,108.2 | 109.8% |
| 81806 | Дотуур байр | 330,863.3 | 311,749.0 | 19,114.2 | 94.2% |
| 81816 | Хүүхдэд ээлтэй сургалтын орчин | 77,040.8 | 77,040.7 | 0.06 | 100% |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 81823 | Боловсролын байгууллагын багш ажилтны мэргэжил дээшлүүлэх | 22,830.9 | 16,662.0 | 6,168.8 | 73% |
| 81844 | Гүнзгийрүүлсэн болон төрөлжсөн | 2,800.0 | 2,800.0 | 0.00 | 100% |
| 81875 | Сургуулийн нэмэлт хөтөлбөр хэрэгжүүлэх | 15,048.0 | 7,471.6 | 7,576.3 | 49.7% |
| 83602 | 3Г болон 3Д-ын нөөц хөрөнгөөс хуваарилсан | 1,200.0 | 1,200.0 | 0.00 | 100% |
| 81834 | Боловсролын стандарт сургалтын орчин | 3,284,587.4 | 3,017,219.7 | 267,367.6 | 91,8% |
| 81835 | Сургалтын хэвийн үйл ажиллагаа | 262,365.6 | 262,248.7 | 0.00 | 100% |
| **Орон нутгийн төсвөөс** | | | | | |
| 80109 | ТЗШ-ийн байгууллагын тогтмол зардал | 452,497.6 | 431,653.5 | 20,844.1 | 95.3% |
| **НИЙТ** | | | | | **81.5%** |

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтээр 452,497.6 мянган төгрөгийн санхүүжилт авсан түлш халаалтын төлбөр, гэрэл цахилгаан урсгал засварын зардалд зарцуулсан байна.

**Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн**

Тайлант хугацаанд төсөл, хөтөлбөр хэрэгжүүлээгүй байна.

### *3.5.4* Худалдан авах ажиллагааны гүйцэтгэлийн талаар

Тайлант оны худалдан авах ажиллагаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нийцсэн, Засгийн газрын 2021 оны 124 дүгээр тогтоолоор баталсан босго үнийг баримталсан байна. Худалдан авах ажиллагаатай холбоотой зөрчилтэй зүйл илрээгүй болно.

Худалдах, худалдан авах гэрээ байгуулж худалдан авалт хийсэн байна.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана." гэж заасны дагуу Тосонцэнгэл сумын ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг "Хаан соёмбо аудит ХХК"-ны гэрээт аудитор Б.Цэрэндэжид гүйцэтгэж, анхан шатны хяналтыг Завхан аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Ц.Оюунсувд хийж, чанарын хяналтыг аудитын менежер Х.Болдбаатар, дарга, тэргүүлэх аудитор Д.Бат-Ундраа нар хэрэгжүүлсэн.

Тосонцэнгэл сумын ерөнхий боловсролын 2 дугаар сургууль нь 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Завхан аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн 07 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг "Дунд" гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт орлогыг 4,537,100.3 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 68,056.5 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 51,042.3 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг дахин хянаж, шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн шалгуур үзүүлэлтээс тухайн шалгагдагч байгууллагатай хамааралтай 31 заалтыг сонгож, горим сорил хэрэгжүүлсэн бөгөөд алдаа, зөрчил илрээгүй байна.

### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Байгууллагын 2024 оны санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн нийцлийн асуудлыг авч үзсэн бөгөөд аудитын санал дүгнэлтэд хамруулан үзээгүй болно.

#### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 5 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль, тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

#### 4.5.1 Завсрын аудитын талаар

Тосонцэнгэл сумын ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн 2024 оны санхүүгийн тайланд завсрын аудит хийгдэж анхан шатны баримтгүй болон анхан шатны баримтын бүрдэл дутуу ажил гүйлгээг хүлээн зөвшөөрч бүртгэн тайлагнасан зөрчил, анхны өртгөө элэгдлээрээ нөхсөн тэг үлдэгдэлтэй байгаа хөрөнгийг дахин үнэлж ашиглалтын хугацааг сунгаагүй зэрэг зөрчлүүд илэрч зөвлөмжийг хүргүүлэн хэрэгжилтийг бүрэн хэрэгжүүлсэн.

#### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар зөрчилгүй санал дүгнэлт өгсөн бөгөөд зөвлөмж өгөөгүй, албан шаардлага аваагүй 201.0 мянган төгрөгийн актыг бүрэн барагдуулсан байна.

*Хүснэгт 4 Төлбөрийн акт,* албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

*/мянган төгрөгөөр/*

| Үзүүлэлт | Өмнөх аудитын үзүүлэлт | | Биелэлт | | |
|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Акт | 1 | 201.0 | 1 | 201.0 | 100% |
| Албан шаардлага | | | | | |
| Зөвлөмж | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| **Нийт дүн** | **1** | **201.0** | **1** | **201.0** | **100%** |

### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал тодорхойлогдоогүй байна.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 357.6 мянган төгрөгийн алдаа илэрч төлбөрийн акт тогтоож, 1 зөвлөмж хүргүүллээ.

***Залруулсан алдаа:***

Байхгүй

**Шийдвэрлэсэн байдал:** Байхгүй

### 5.1 Төлбөрийн акт:

- ***<u>Илэрсэн алдаа:</u>*** Дотуур байрны хүүхдийн хоолны материалын үлдэгдлийг газар дээр нь тоолоход 7.2 кг үхрийн мах муудсан, 22.6 кг үхрийн мах, нийт 357.6 мянган төгрөгийн хүнсний материал дутагдсан
- **Шийдвэрлэсэн байдал:** Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасныг тус тус зөрчсөнд 357.6 мянган төгрөгийн акт тогтоов.

### 5.2 Албан шаардлага: өгөгдөөгүй

### 5.3 Зөвлөмж

***Илэрсэн алдаа:*** Үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй 127 төрлийн 313,600.8 мянган төгрөгийн хөрөнгө элэгдээрээ анхны өртгөө нөхсөн, үлдэгдэл өртөггүй хөрөнгө бүртгэлтэй байна. . Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйл 5.1.4-д "үнэн зөв байх", 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах", ТӨБЗГ-ын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 7.1-д "Төрийн өмчит хуулийн этгээд нь эзэмшилдээ байгаа илүүдэл хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлж шийдвэрлүүлнэ" гэж заасантай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

***Өгсөн зөвлөмж:*** Дахин үнэлгээ хийх шалгуур хангасан хөрөнгөнд үнэлгээ хийж бүртгэлд тусгах, цаашид ашиглах боломжгүй хөрөнгүүдийг холбогдох газрын зөвшөөрлийн дагуу данснаас хасах арга хэмжээ авч, үндсэн хөрөнгийн бүртгэлийг цэгцлэх;

Энэхүү зөвлөмжийг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5 дахь хэсэгт заасны дагуу төлөвлөгөө гарган хэрэгжүүлж, биелэлтийг 2025 оны 06 дугаар сарын 15-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчил нь бидний тогтоосон материаллаг түвшингээс бага байгаа тул **"Өөрчлөлтгүй"** дүгнэлт өглөө.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

*/мянган төгрөгөөр/*

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Дотуур байрны хүүхдийн хоолны материалын үлдэгдлийг газар дээр нь нүд үзэн тоолоход 7.2 кг үхрийн мах муудсан, 22.6 кг үхрийн мах дутагдсан | 1 | 357.6 | | | | | 1 | 357.6 | | | | |
| Анхны өртгөө элэгдлээрээ нөхсөн 0 үлдэгдэлтэй байгаа 127 нэр төрлийн 313,600,881.54 төгрөгийн хөрөнгийг дахин үнэлж ашиглалтын хугацааг сунгах | 1 | | | | | | 1 | | | | | |
| **Дүн** | | **357.6** | | | | | | **357.6** | | | | |

**АУДИТЫН ТАЙЛАНГ:**

**ХЯНАСАН:**

АХЛАХ АУДИТОР Ц.ОЮУНСУВД

АУДИТЫН МЕНЕЖЕР: Х.БОЛДБААТАР

ДАРГА,ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Д.БАТ-УНДРАА

Огноо: 2025-01-23

АТА6366 9039376
0921106009

**БОЛОВСРУУЛСАН:**

“ХААН СОЁМБО АУДИТ” ХХК ГЭРЭЭТ АУДИТОР Б.ЦЭРЭНДЭЖИД

Огноо: 2025-01-23